

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ,  
ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АЖЛЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 11 дугаар сарын 27 -ны өдөр

№	Хуулийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн	Биелэлт	Хувь
<b>1.НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ</b>						
Зорилт 1. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг нээлттэй болгох						
1	8.6.19.	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүрэн хамруулах ажил зохион байгуулах	11 дугаар сарын 25	- Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо мэдээ, бүртгүүлээгүй хуулийн этгээдийн судалгааг 2 хэлбэрээр гаргаж, бүртгэлд бүрэн хамруулах ажлыг хэрэгжүүлсэн байх	Тайлант хугацаанд нийт 1663 хуулийн этгээдийн оноосон нэрийн хүсэлтийг хүлээн авч баталгаажуулсан. Үүнд: les.e-business.mn-ээр илгээсэн 1289 хүсэлт ирснээс оноосон нэр авах 1253, цахим гэрчилгээ 25, шинээр хуулийн этгээд байгуулах хүсэлт 10 байсныг хүлээн авч боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд эцсийн өмчлөгчийн нөхөн бүртгэл 25, нэмэлт өөрчлөлт 65 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлээд байна.	
Зорилт 2. Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох						
2	8.2.1-8.2.10	Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын мэдээллийг нээлттэй байлгах, нөхөн байршуулах, тухай бүр шинэчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих	Байнга	-Жагсаалт дахь мэдээлэл 5-р сарын 1-ний өдрийн дотор бүрэн байршсан байна. -Мэдээлэл байршуулах хариуцсан нэгж ажилтан хуваарийг баталсан байна. -Цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан, мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангасан байна	-Байгууллагын чиг үүрэг зорилго зорилт үйл ажиллагааны чиглэлийг хэлтсийн байранд байрлах мэдээллийн самбарт байршуулсан, мөн хэлтсийн вэб сайтад байршуулж тухай бүр шинэчлэн ажилласан. - Хэлтсийн мэдээллийн ил тод байдлын самбарт Төсөв санхүү, бараа материал худалдан авалтын мэдээллийг сар бүр байршуулдаг мөн хэлтсийн вэб сайтг шилэн данстай холбон мэдээллийг байрлан ажиллаж байна.	
3	8.4.1-8.4.28	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийг нээлттэй байлгах, хяналт тавих			- <b>Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:</b> үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээний төрөл тус бүрээр бүрдүүлэх материалын жагсаалтыг хэвлэж, иргэдэд олгох ажлыг зохион байгуулахын зэрэгцээ үйлчилгээний зааланд мэдээллийн самбар хийж	
4	8.6.1-22	Хуулийн 8.6-д заасан мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах				

				<p>байршуулсан.Түүнчлэн хэлтсийн web сайтад 18 төрлийн үйлчилгээг авахад шаардагдах бүрдүүлбэрийг байршуулсанаар улсын бүртгэлд бүртгүүлэх бүрдүүлбэрүүдийг хэлтсийн байранд ирж үйлчилгээний ажилтангаас зөвлөгөө авах шаардлагагүй болоод байна. Бүх төрлийн лавлагаа, тоон гарын үсэг, үндэсний энгийн цахим гадаад паспорт, үрэгдүүлсэн гээгдүүлсэн иргэний үнэмлэхийг улсын бүртгэлийн цахим машин/киоск/-аар авах заавар зөвөлгөөг цахим буланд байршуулан ажиллаж байна. Үйлчилгээний зааланд байршуулсан "Цахим туслагч" булангийн зөөврийн компьютераар "E-Mongolia" системээр дамжуулан иргэний улсын бүртгэлийн 2483 иргэнд давхардсан тоогоор лавлагаа олгон ажиллалаа.</p> <p><b>- Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:</b> үзүүлж буй үйлчилгээний төрөл тус бүрээр бүрдүүлэх материалын жагсаалтыг хэвлэж хэлтсийн үйлчилгээний заалаар үйлчлүүлж буй иргэд тарааж, мөн Хуулийн этгээд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгаас Улсын бүртгэлийн ажилтны баярыг угтсан "Эрүүл амьдрал-Идэвхитэй хөдөлгөөн" 1 сарын аян зохион байгуулж аяны хүрээнд иргэдэд 16 төрлийн үйлчилгээний бүрдүүлэх материалын жагсаалтыг хэлтсийн вэб хуудсанд байршуулан мэдээлэл хүргэн ажилласан.. Хэлтсийн байранд байршуулсан Цахим Өвөрхангай булангаас "Коиск" машинаар лавлагаа мэдээлэл олгон, Гэрэгэ системээр үйлчилгээний төлбөр хураамжийг иргэдэд чирэгдэл багатай хүргэх үүднээс тогтмол лавлагааг банк болон банк бус санхүүгийн байгууллагын зээлийн дараах болон бусад лавлагаа 2315 олгоод байна. ХЭЭХУБТасаг Хархорин, Уянга, Төгрөг, Баян-Өндөр, Бат-өлзий суманд нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэх болон 16 төрлийн үйлчилгээгээр түргэн шуурхай хүрч ажиллаж байна. Үйлчилгээний</p>
--	--	--	--	--

					зааланд байрших улсын бүртгэлийн үйл ажиллагааны ил тод байдлын самбарт үйл ажиллагаагаа сурталчилан сар бүр гардаг мэдээний грацик үзүүлэлт, гарын авлага, хууль дүрэм журам, мэдээ мэдээллийг байршуулан ажиллав.
<b>Зорилт 3. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлт, хэрэгжүүлэх, хүн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг хангах</b>					
5	12.4	Өөрийн боловсруулсан нээлттэй өгөгдлийг цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтлэх, тогтмол шинэчлэх	Нээлттэй өгөгдлийн жагсаалт батлагдсан ы дараа	-Нээлттэй өгөгдлийг мэдээлэл хариуцагч өөрийн цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлнэ. -Нээлттэй өгөгдлийг ашиглах нөхцөлийг тодорхойлсон байна.	-Тус хэлтсийн иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, болон хэлтсийн өргөдөл гомдол, санхүүгийн тайлангуудыг нийтэд ил тод хүртээмжтэй хүргэх үүднээс мэдээллийн самбар, хэлтсийн вэб хуудаст, Facebook хуудсанд 175 удаагын мэдээ мэдээллийг байршуулан ажилласан байна. - Сар бүрийн газар болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тоон мэдээ, хувийн хэрэг баяжилтын тоон мэдээллүүдийг сар болгон гаргаж хэлтсийн мэдээллийн самбар болон хэлтсийн web хуудсанд дээрх мэдээллүүдийг зурган файл болгон байршуулахаас гадна иргэдэд бүртгэлийн үйлчилгээний гарын авлага тараах материал, үйлчилгээни үнэ хөлс зэргийг ойлгомжтой байдлаар байршуулан ажиллаж байна. - Сар болгон иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийг улсын бүртгэлээр хийж гүйцэтгэсэн бүртгэлийн тоон мэдээ, архивын тоон мэдээллүүдийг сар болгоны 25-ны дотор гаргаж хэлтсийн мэдээллийн самбар болон хэлтсийн web хуудсанд дээрх мэдээллүүдийг зурган файл болгон 46 удаа байршуулав. - E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн портал системээр дамжуулан 16 төрлийн үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд одоогийн байдлаар “Хаан банк”, “Бэрсфинанс” ББСБ-ийн зээлийн гэрээний дараах лавлагааг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулж ажиллаж байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ

					<p>авахыг хүссэн иргэдийн тусгайлан уулзах хүсэлтийг тэр даруйд хүлээн авч хуулийн дагуу зөвлөгөөг өгч шийдвэрлэж ажиллаж хэвшээд байна.</p> <p>- Хуулийн этгээдийн улсын бүртгэлээр тайлант хугацаанд 1938 хүсэлт /ers.gasr.mn-649, service.e-mongolia 474, les.business.mn 815/-ийг хүлээн авч зохих журмын дагуу бүртгэлийн хөтлөн ажилласан. Шинээр байгуулагдсан 238, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан 229, салбар төлөөлөгчийн газрын бүртгэл 16, татан буугдсан 8, дахин гэрчилгээ олгосон 50, тамга, тэмдэг хураан авсан 46, хяналтын дугаар олгосон 264 байна. Мөн 165 лавлагаа, хуулбарыг олгосон.</p>	
6	17.1.1-17.1.11	Хүн хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг хангах ажлыг зохион байгуулах	Байнга	<p>-Хүсэлт гаргагчийг хүлээн авч уулзах, цагийн хуваарийг нийтэд мэдээлсэн, бүртгэл хөтөлсөн байна.</p> <p>-Мэдээлэл авах хүсэлтийг заасан хугацаанд шийдвэрлэсэн, хариу хүргүүлсэн байна.</p>	<p>Төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-аар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээ, болон Улсын бүртгэлийн цахим машин/киоск/, Төлбөрийн цахим машин/гэрэгэ киоск/, Төрийн үйлчилгээний цахим машин /ТҮЦ/ машинуудын үйл ажиллагааг байгууллагын цахим хаяг, фэйсбүүк хаяг, орон нутгийн телевиз, мэдээ, шторк хэлбэрээр иргэдэд сурталчилан ажиллаж байна. Тайлант хугацаанд E-mongolia системээр гадаад паспортын бүртгэл 54, иргэний үнэмлэх 47, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл тайлант хугацаанд хийгдээгүй байна. Нийт 101 иргэнд бүртгэлийг хийлгэж, иргэдэд шуурхай хүргүүлсэн. Үйлчилгээний зааланд байршуулсан "Цахим туслагч" булангийн зөөврийн компьютраар "E-Mongolia" систем, Улсын бүртгэлийн цахим машин/киоск/-р дамжуулан иргэн, эд хөрөнгө хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр банк болон банк бус санхүүгийн байгууллагын зээлийн дараах болон бусад лавлагаа 988, иргэнд 1415 лавлагаа, иргэний бүртгэлээр 2638 лавлагааг олгож ажиллалаа. Хуулийн этгээдийн 292 лавлагаа олгогдсон.</p>	

7	34.1.1	Нийтийн мэдээллийн дэд бүтцийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, хийгдсэн үйлдлийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах	Байнга	-Дэд бүтцийн тасралтгүй, хэвийн ажиллагааг ханган холбогдох журмын хэрэгжилтийг хангасан байна.	-Программ хангамжууд нь нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангасан улсын бүртгэгчийн эрх тус бүртээ нууцлалтай тул гадны хүн системд нэтрэх мэдээллийг авах боломжгүй юм. - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн EPRS2 программ, албаны хэрэгцээнд ашиглаж байгаа компьютерийн нэвтрэх нууц үгийг улсын бүртгэгч нар улирал тутамд сольж ажиллаж байна. - Иргэний улсын бүртгэлийн программын нууц үг болон албаны хэрэгцээнд ашиглаж байгаа компьютерийн нэвтрэх нууц үгийг улсын бүртгэгчид улирал тутамд сольж ажиллаж байна.	
<b>2. ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ</b>						
Зорилт 1. Хуульд заасан үндэслэлээр мэдээлэл цуглуулах, боловсруулах						
8	6.3	Хүнийг тодорхойлох боломжгүй болгож мэдээллийн эзний мэдээллийг нээлттэй өгөгдөл болгохдоо Нийтийн мэдээллий ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтлах	Байнга	мэдээллийг нээлттэй өгөгдөл болгохдоо Нийтийн мэдээллий ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтлах	- Иргэний улсын бүртгэлийн бүртгэл хөтлөх лавлагаа авахад тухайн иргэний хурууны хээгээр бүртгэл хийж байна. Тухайн иргэний хурууны хээг зөвхөн дотооддоо ашигладаг бөгөөд гадагш мэдээллийг задруулах боломжгүй болно. - Мэдүүлэг хүлээлгэн өгч байгаа иргэдийн материалыг шалган шаардлага хангасан тохиолдолд хурууны хээгээр мэдүүлэгийг хүлээн авч хэвшсэн.Тухайн иргэний хурууны хээг зөвхөн дотооддоо програмд иргэн өөрөө мөн бишийг шалгахад танилтын журмаар ашиглаж гадагш мэдээллийг задруулах боломжгүй болно	
9	10.4	Хүний генетик болон биометрик мэдээллийг цуглуулах, ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж ажиллах	Байнга	Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангасан байна	Тус хэлтэс нь иргэний хурууны хээний мэдээллийг зөвхөн улсын бүртгэлд бүртгэл хөтлөхөд зориулан ашигладаг бөгөөд өөр бусад зорилгоор ашигладаггүй. Программ хангамжууд нь нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангасан улсын бүртгэгчийн эрх тус бүртээ нууцлалтай тул гадны хүн нэтрэх мэдээллийг авах боломжгүй юм. Тоон гарын үсэг буюу цахим гарын үсгийг олгох ажлыг аймгийн хэмжээнд 78673 иргэн авах ёстойгоос 2022-2023 онд 47200 иргэнд 19 сумын улсын бүртгэгч Улсын бүртгэлийн цахим машин/киоск/,	100

					хэлтсийн 2 бүртгэгч, Гэрэгэ киоск машинуудаар олгон ажиллаж байна.	
10	27	Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийг ажлын байранд хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор байршуулах, мэдээлэлд хандах эрхгүй этгээд хандахаас урьдчилан сэргийлэх техникийн болон үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх	Байнга	Дүрсний бичлэгт мэдээллийн эзнээс бусад хүний мэдээлэл байгаа тохиолдолд дүрсний бичлэгийг үзүүлэх, хуулбарлаж өгөхгүй байх.	Тус хэлтэс шинэ байранд орсноор хяналтын камерын тоог нэмж 36 камертай болсон бөгөөд хэлтсийн даргын өрөөнд нэгдсэн төхөөрөмж байрладаг, ажлын байранд хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор ашигладаг шаардлагатай тохиолдолд хэлтсийн даргын зөвшөөрлөөр иргэн болон хууль хяналтын байгууллагад бичлэгийг үзүүлдэг, камернуудыг интернэтэд холбоогүй мөн хэлтсийн даргын өрөөнд байрладаг тул эрхгүй этгээд хандах боломжгүй юм.	100
<b>3. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ</b>						
Зорилт 1. Кибер аюулгүй байдлыг хангах						
11	9.4	Мэдээллийн аюулгүй байдлын аудит тагнуулын байгууллагаар хийлгэх				
12	19.2	Кибер халдлага, зөрчлийн үед дагаж мөрдөх төлөвлөгөөг хэрэгжүүлэх				
13		Мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн найдвартай, тасралтгүй байдлыг хангах, гэмтэл саатлын үед сэргээн ажиллуулах төлөвлөгөөг дагаж мөрдөх	Тогтоосон хугацаанд	-Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг 2 жил тутамд хийлгэсэн байна. -Кибер аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг жил тутамд, эсхүл мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний өөрчлөлт хийгдэх бүрд хэсэгчилэн, эрх бүхий байгууллагын шаардсанаар тухай бүр хийлгэж, гарсан дүгнэлт, зөвлөмж шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	-Аймгийн тагнуулын газраас 2021 онд мэдээллийн аюулгүй байдал, эрсдлийн талаар шалгалт хийсэн дээрх шалгалтыг 2 жил тутамд эрсдэл сүлжээний аюулгүй байдлын үнэлгээг хийж судалгаа авч ажилладаг. 2023 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын шалгалтыг хийлгэсэн байна. - Кибер халдлага, зөрчлийн үед дагаж мөрдөх журмыг Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан. Тус журмыг дагаж мөрдөн төлөвлөгөө гарган ажиллаж байна.. - Тус аймгийн 19 сумыг улсын бүртгэлийн нэгдсэн онлайн сүлжээнд холбосноос хойш сумдын сүлжээ тасрах сүлжээний төхөөрөмж шатах эвдрэх тохиолдол их гарч байна. Сүлжээний асуудал үүссэн Арвайхээр, Бат-Өлзий, Богд, Гучин-Ус, Хужирт, Зүүнбаян-улаан, Сант, Тарагт, Есөнзүйл сумдын бүртгэгчтэй холбогдон суманд очиж ажиллан УБЕГ-ын сүлжээний инженерүүд болон холбогдох байгууллагатай хамтарч сүлжээний гэмтэл, тоног төхөөрөмжийн гэмтэл, шилэн кабелийн гэмтлийг арилгаж хэвийн ажиллагааг ханган ажиллаж	90

					<p>байна. Хэлтсийн болон сумдын улсын бүртгэгчдийн бүртгэлийн онлайн сүлжээнд хандаж програмд нэвтрэх эрхүүдийг дотоод журманд заасан хугацаанд солиулах, тэдгээрийн ашигладаг тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарах бүрт шаардлагатай арга хэмжээг авч програмын болон тоног төхөөрөмжийн тохиргоог хийн системийн лог бүртгэл хийх боломжоор ханган хяналт тавин ажиллаж байна.</p> <p>- Иргэний эрхийн улсын бүртгэл, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэл, зэрэг бүртгэлүүдийн улсын бүртгэгчдийн онлайн програмд ашиглаж байгаа програм хангамжуудын шинэчлэл/update/-ийг тухай бүр шинэчлэж хэвийн ажиллах боломж бололцоог цаг алдалгүй түргэн шуурхай хийж гүйцэтгэж байна.. Үүнд иргэний 7 төрлийн бүртгэлийн, <a href="http://www.civil.mn">www.civil.mn</a> програмын шинэчлэл сайжруулалт, Цахим гарын үсэг олголтын PKI, <a href="http://www.sign.mn">www.sign.mn</a> програмууд, ЭХЭУБ-н <a href="http://www.eprs.mn">www.eprs.mn</a> онлайн програмын шинэчлэл сайжруулалт, хуулийн этгээдийн <a href="http://www.ers.gasr.mn">www.ers.gasr.mn</a>, хяналт шалгалтын програм <a href="http://www.app-audit.gasr.mn">www.app-audit.gasr.mn</a>, гадаад паспортын зураг засварын програм, иргэний үнэмлэхний зураг засварын Албан хэрэг хөтлөлтийн <a href="http://www.intranet.mojha.mn">www.intranet.mojha.mn</a>, г.м бүртгэлийн бүх програмуудын шинэчлэл тохиргоог хийж төрийн бүртгэлийн үйлчилгээний тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн бүртгэлийн цахим үйлчилгээний машин/киоск/, Төлбөр төлөлтийн цахим төхөөрөмж/гэрэгэ киоск/ зэргийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.</p>	
<b>4. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА</b>						
14	-	Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль тогтоомж, нээлттэй өгөгдлийн талаар сурталчлах, алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх	Жилдээ	-Зс доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна. -Албан хаагчдын мэдлэг дээшилсэн байна. -цахим хөгжлийн багц хуулийг	Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/1863 дугаартай тушаал, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахим системд хөтлөх журам", Улсын бүртгэлийн ерөнхий	

		талаарх арга хэмжээ, сургалт зохион байгуулах		хэрэгжүүлэх хүрээнд сурталчилгааны ажлууд хийгдсэн байна.	газраас ирүүлсэн 5/4664 дугаартай "ЭУБ-10,ЭУБ-14,ЭУБ-15 маягтуудын нэмэлт өөрчлөлт болон шинээр батлагдсан маягтууд, мөн 5/3367 ,5/1854,5/4053,5/4664,5/3367 дугаартай чиглэлүүдийг хэлтсийн 46 алба хаагчдад нийт 7 удаагийн танилцуулга хийгдсэн. Тухайн журмын өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэгч байгууллага болох "Хаан банк","Хасбанк","Төрийн банк","Голомт банк"-ны эдийн засагчдад 2023 оны 05-р сард журам, зааврын өөрчлөлтүүдийн талаарх нэгдсэн сургалтуудыг зохион байгуулсан.Сургалт зохион байгуулсан тоо-3, хамрагдсан алба хаагчид-46, иргэн,хуулийн этгээд-32. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний энгийн цахим гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ыг нийт хэлтсийн алба хаагчдад танилцуулж, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Аймгийн тагнуулын газраас төрийн болон албаны нууц, кибер аюулгүй байдлын тухай хууль, халдлагаас хэрхэн сэргийлэх талаар сургалт авч хэлтсийн нийт албан хаагчдыг онлайн болон танхимаар хамруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа.	
15	-	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар сурталчлах, сургалт зохион байгуулах				90